

**САНГИЙН САЙДЫН 2022 ОНЫ 197 ДУГААР ТУШААЛААР
БАТЛАГДСАН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН НЯГТЛАН
БОДОХ БҮРТГЭЛИЙН ПРОГРАММД ДҮГНЭЛТ ГАРГАХ
АЖЛЫН ХЭСГИЙН ХУРАЛДААНЫ ДҮГНЭЛТ**

2025 оны 3-р сарын 28-ний өдөр

Улаанбаатар хот

1. Сангийн сайдын 2022 оны 197 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага”-ыг дор дурдсан нягтлан бодох бүртгэлийн программ хангамж хангасан байна. Үүнд:

А. Нийтийн ашиг сонирхлын буюу том аж ахуйн нэгжид ашиглах боломжтой нягтлан бодох бүртгэлийн программ хангамж:

1. “Интерсолюшнс менежмент” ХХК-ийн “Динамикс 365 Бизнес централ”;
2. “Интерактив би ай” ХХК-ийн “ОЧ 7.7”.

Б. Жижиг, дунд аж ахуйн нэгжид ашиглах боломжтой нягтлан бодох бүртгэлийн программ хангамж:

1. “Менежволл” ХХК-ийн “OdooERP-16”;
2. “Смарт ложик” ХХК-ийн “SmartBalance v24.12.1”;
3. “Даянсофт” ХХК-ийн “Dayansoft ERP v9.12”;
4. “Эм эс пи ди ти” ХХК-ийн “DManager v3.1”.

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программыг нийтэд мэдээлэх” гэж заасны дагуу дээрх 6 компанийн программ хангамжийг нийтэд мэдээлэх нь зүйтэй.

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА:

Сангийн яамны Нягтлан бодох
бүртгэлийн бодлогын газрын
дарга

Б.Болормаа

ГИШҮҮД:

Сангийн яамны Төрийн
сангийн газрын Санхүүжилт,
тайлан бүртгэлийн хэлтсийн
дарга

С.Мөнхсүх

Гааль, татвар, санхүүгийн
мэдээлэл технологийн
төвийн захирал

Т.Батбилэг

Монголын нягтлан
бодох бүртгэлийн
хүрээлэнгийн тэргүүн

“БДО Аудит” ХХК-ийн ерөнхий
захирал

“Магнай трейд” ХХК-ийн
санхүү, бүртгэлийн газрын
захирал

 Л.Дондог

 Г.Баянмөнх

 С.Цэцэгмаа